



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/14 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багахангай үйлдвэрлэл технологийн паркийн мэдээлэл холбоо хангамжийн зураг төслийн ажил (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг) болон Багахангай дүүргийн үйлдвэрлэл технологийн паркийн байгал орчны нөлөөллийн үнэлгээ (Улаанбаатар хот, Багахангай дүүрэг)-ний үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн

ахлагч

Д.Хүрэлбаатар

Засаг даргын Тамгын газрын

Тохижилт, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Гишүүд

Б.Хишиг-Ундрал

Багахангай тохижилт ОНӨААТҮГ-ын инженер

Г.Батням

Багахангайн Үйлдвэрлэл технологийн паркийн нягтлан бодогч

Х.Батсайхан

1 дүгээр хорооны иргэн

Нарийн бичиг

Э.Урансайхан

Худалдан авах ажиллагааны албаны худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн

2.Хууль тогтоомжийн дагуу үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Ажлын хэсэг (Д.Хүрэлбаатар)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа) -д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД

AJIL/2024 он ажил/захирамж

11230000-23